



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/08

Өмнөдэлгэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/528 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Амны хөндийн эрүүл мэндийн сургалтын удирдамжийг нэгдүгээрт, шаардагдах зардалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах 438000 (дөрвөн зуун гучин найман мянга) төгрөгийг нийгмийн эрүүл мэндийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Сэр-Од)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.АРИУНТУНГАЛАГ